

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

№ Т-22/01

Улаанбаатар хот

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “**Компани**”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “**ХЭЭХ**”) 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандийн гудамж-39, Корпорейт Хотел & Конвейншн центр (Corporate Hotel & Convention Centre)-ийн 2 давхарт байрлах Эвент танхимд зохион байгуулагдав. ХЭЭХ-д оролцсон албан тушаалтнууд:

- ХЭЭХ-ын дарга: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “**ТУЗ**”)-ийн дарга О.Болдбаатар,
- ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга: Компанийн Санхүү, үйл ажиллагаа хариуцсан захирал М.Түвшинжаргал,
- ХЭЭХ-ын Тооллогын комиссын дарга, Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс ХХН-ийн партнер С.Батбуян,
- Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд: С.Боргил, Ж.Жаргалсүрэн,
- Компанийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр,
- Хараат бус аудитор: “Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК, аудитор Н.Нарантуяа, Ц.Тогтохбаяр,
- Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд нар оролцож, ХЭЭХ-ыг хурал зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал хөтлөн явуулав.

ХЭЭХ-ын ирц: Нийт саналын эрх бүхий хувьцааны 84.36 %

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. ЛэндМН ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн болсон байна. Цар тахлын дараа хурлаа танхимаар зохион байгуулж хувьцаа эзэмшигчид та бүхэнтэйгээ уулзаж байгаадаа баяртай байна.

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хүмүүсийг танилцуулъя. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга О.Болдбаатар; “ЛэндМН ББСБ” ХК-ийн Ерөнхийлөгч Кацухино Мадоно; “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр; Тооллогын комиссын дарга “ЭмДиЭс энд ХаанЛекс ХХН”-ийн Партнер С.Батбуян; “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд; “ЛэндМН ББСБ” ХК-ийн Санхүү үйл ажиллагааны газрын захирал, Хурал зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал миний бие тус тус оролцож байна. Мөн ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Боргил, ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн, хараат бус аудиторууд хуралд оролцож байна.

Ингээд хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийн дагуу Хурлын ирцийг мэдээлнэ үү хэмээн Тооллогын комиссын дарга С.Батбуян таныг индэрт урьж байна.

Тооллогын комиссын дарга С.Батбуян :

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид маань хурлын танхимд хүрэлцэн ирж <https://survey.lend.mn/> цахим хуудаст хандаж саналаа өгөх нэвтрэх нэр, нууц үг авснаар саналын эрх бүхий хувьцаа эзэмшигч нарын ирцийг бүртгэсэн байна.

Хувьцаа эзэмшигч та бүхэнд ирц бүртгүүлэхэд олгосон мандатад буй QR кодыг уншуулан <https://survey.lend.mn/> цахим хуудсанд өөрийн гар утас болон компаниас бэлтгэсэн компьютер ашиглан саналаа өгөх боломжтой. Та саналаа урьдчилан өгөх боломжтойгоос гадна ХЭЭХ-аар хэлэлцэх асуудал тус бүрийг танилцуулж, асуулт, хариулт, хэлэлцүүлэг явагдсаны дараа <https://survey.lend.mn/> цахим хуудсаар санал хураалт явагдана. Хэрэв саналаа урьдчилан өгсөн бол энэ хэсэгт дахин санал өгөх боломжгүй. ХЭЭХ-ын дэгийн дагуу санал хураалтын хугацаа дуусахад санал хураалтын цахим хуудас хаагдах тул үүнээс хойш санал өгөх боломжгүй болох ба та санал өгөх системд саналаа бүрэн гүйцэд, зөв бөглөөгүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасны дагуу саналын хуудас хүчингүйд тооцогдоно гэдгийг та бүхэн анхаараарай.

Ингээд та бүхэнд “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн мэдээг танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчид маань 2023 оны 04 сарын 14-ний өдрийн 18:00 цаг хүртэл брокер, диллерийн компаниудаар дамжуулан санал өгөх боломжтой байсан. Шалгаж үзэхэд ийнхүү ирүүлсэн санал гараагүй тул хурлын ирцэд тооцох санал байхгүй болохыг тэмдэглэж байна.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрх бүхий хувьцааны 84.36 хувийг эзэмшиж байгаа 58 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирж бүртгүүлсэн байх тул Компанийн тухай хуулийн 69.1¹-т зааснаар ХЭЭХ хуралдуулах ирц бүрдэж, ХЭЭХ хүчин төгөлдөр болж байгааг хувьцаа эзэмшигчид болон ХЭЭХ-ын даргад мэдээлж байна.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Тооллогын комиссын дарга С.Батбуяндаа баярлалаа.

Одоо та бүхний өмнө “ЛЭНДМН ББСБ” ХК-ийн ТУЗ-н дарга, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга О.Болдбаатар таныг Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулна уу хэмээн индэрт урьж байна.

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

Төлөөлөн удирдах зөвлөл болон компанийн нийт хамт олны өмнөөс эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

2022 оны хурлын ирц бүрдсэн учраас албан ёсоор хурлыг нээж байгаадаа таатай байна.

2022 он “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд бизнесийн өндөр өсөлтийг үзүүлсэн жил байлаа. Тус оны онцлох үйл явдлаас товч дурдвал:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн охин компани “ЛэндМН АктивТЗК”ХХК нь 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зөвшөөрлөө авч, улмаар 4.85 тэрбум төгрөгийг олон нийтээс амжилттай татан

¹ 69.1.Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

- төвлөрүүллээ. Мөн Лэнд ХБҮЦ нь сар бүр өгөөж хуваарилах нөхцөлтэй арилжаалагдсан ба нийт хөрөнгө оруулагчдын хуваарьт өгөөжийг сар бүр тогтмол олгосоор байна.
2. “ЛэндБонд”-ын Транч II-ын анхдагч зах зээлийн арилжаа 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд зохион байгуулагдаж нийт 188 хөрөнгө оруулагчдаас 3.1 тэрбум төгрөгийг арилжаа зарлагдсан хугацаанаас өмнө татан төвлөрүүлж, анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдаж, 2 удаагийн Транчаар буюу 2021 онд 2.5 тэрбум, 2022 онд 3.1 тэрбум нийт 5.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүллээ. 2022 онд арилжаалагдсан “Лэндбонд”-ийн өгөөжүүд үнэт цаасны дансанд хугацаандаа тус тус байршуулсан.
 3. Монгол улс Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийг ЛэндМН дэмжин “Санхүүгийн зохицуулах хороо”-нд мод тарих үүрэг амлалтаа хүргүүллээ. ЛэндМН нь байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөр, ногоон санхүүжилтийг дэмжин ажиллахаар боллоо.
 4. 2022 онд зээлийн багц 2021 оны жилийн эцсээс 2.1 дахин нэмэгдэж 71.1 тэрбум төгрөг, цэвэр ашиг 5.53 тэрбум төгрөгт хүрсэн байна. “ЛэндМН ББСБ”ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаас компанийн нэгж хувьцаанд 1.75 төгрөгийн ногдол ашиг тооцон олгохоор тогтоож, 2022 оны цэвэр ашгийн 23.4 хувийг буюу 1.3 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлээд байгаа билээ. 2023 онд бид эрч хүч, өндөр ур чадвар, арвин туршлага бүхий авьяаслаг мэргэжилтнүүдээр бүл нэмж, удирдлагын багтаа хүч нэмж буй бөгөөд эдгээрээс хамгийн онцлогтой хүн бол Япон мэргэжилтэн ЛэндМН-ийн Ерөнхийлөгч санхүүгийн салбарын арвин их туршлагатай Кацухико Мадоно юм. Цаашид “ЛэндМН ББСБ” ХК-ийн хамт олон өөрсдийн үнэт зүйл болсон инновац, нээлттэй хамтын ажиллагааг дараагийн түвшинд хүргэн үсрэнгүй өсөлтийг үзүүлж, нийт Хувьцаа эзэмшигч, харилцагч, хөрөнгө оруулагч, бизнесийн түнш, хамтрагч нартаа үнэ цэнийг бүтээн ажиллахад бүх хүчээ зориулах болно.
 5. Бид КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан өнгөрсөн жилүүдэд Хувьцаа эзэмшигчдийн хурлаа онлайн хэлбэрээр явуулж байсан бол энэ удаагийн хурлаа танхимын хэлбэрээр зохион байгуулж байгаад баяртай байна.

Та бүхэнд ХЭЭХ-ын дэгийг танилцуулъя.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах
1	Хурлын ирц бүртгэх	11:00-12:00	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	12:00-12:05	Тооллогын комиссын дарга
3	Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах	12:05-12:10	Хурлын дарга
4	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах	12:10-12:25	Гүйцэтгэх захирал
5	Компанийн ТУЗ-ийн тайлан, 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх	12:25-12:30	ТУЗ-ийн дарга

6	Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах	12:30-12:50	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
7	Компанийн ТУЗ-д гишүүнд нэр дэвшигчидийг танилцуулах	12:50-13:00	Хурлын дарга
8	Компанийн ТУЗ-ийн 2023 оны төсвийн саналыг танилцуулах	13:00-13:05	Гүйцэтгэх захирал
9	Компанийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийн төслийг танилцуулах	13:05-13:10	Гүйцэтгэх захирал
10	Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	13:10-13:30	Хурлын дарга, Гүйцэтгэх захирал, ТУЗ-н хараат бус гишүүд
11	Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах	13:30-13:50	Хурлын дарга, Тооллогын комиссын дарга
12	Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах	13:50-14:20	Тооллогын комиссын дарга
13	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах	14:20-14:30	Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга

Энэхүү дэгийн дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал маань явагдана.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах үндсэн 6 асуудлыг хэлэлцэж, танилцахаар байна. Үүнд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;
5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг батлах;
6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Та бүхэнд баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

“ЛЭНДМН ББСБ” ХК-ийн ТУЗ-н дарга О.Болдбаатар таньд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №1-Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг** танилцуулна уу хэмээн “ЛЭНДМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр таныг индэрт урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №1: КОМПАНИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАХ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

“ЛЭНДМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Компанийн ээлжит 6 дахь удаагийн хурал энэ жил зохион байгуулагдаж байна. Хүрэлцэн ирсэн та бүхэндээ маш их баярлалаа.

Энэ удаагийн хурал цар тахлын дараа анх удаа танхимаар явагдаж байгаа гэдгээрээ онцлогтой. Сүүлийн 3 жил, 2019, 2020, 2021 онуудын хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байсан билээ.

Өнөөдрийн хурал дээр 2022 оны үйл ажиллагаагаа ярихаас гадна, 2023 онд юу хийхээр зорьж байгаа, шинэ бүтээгдэхүүний төлөвлөгөөг мөн та бүхэнд хүргэх болно. Та бүхэн маань хуралдаа идэвхтэй оролцож, бидэнтэй хамт байгаараа хэмээн хүсэж байна.

2022 оны бизнесийн үйл ажиллагааг эхлээд танилцуулъя. 2022 онд цар тахлын нөхцөл байдал нааштай болсон тул үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагааг үе шаттай тэлэх арга хэмжээг авч ажилласан байна. Үүний үр дүнд:

- ✓ Зээлийн багц: 71 тэрбум төгрөгт хүрээд байна.
- ✓ Үйл ажиллагааны өсөлт: 110%-аар өссөн байна. Салбарын дунджаас үзэхэд энэ өсөлт бол 2-3 дахин их хэмжээтэй өссөн жил байна. Энэ өсөлтөд хамгийн их нөлөөлсөн өсөлт бол хэрэглэгчд байгаа юм.
- ✓ Аппликейшн татсан хэрэглэгчдийн тоо: 1,1 саяд хүрсэн байна. Энэ бол Монгол Улсын 18 насанд хүрсэн хүний ½ буюу 50% гэсэн үг юм.
- ✓ Идэвхтэй үйлчлүүлэгч: Зээлийн гэрээ байгуулаад үйлчилгээг өдөр тутамдаа ашиглаж буй 196 мянган хэрэглэгч байна. 196 мянган харилцагчийн маань 65% нь хотод, 35% нь хөдөө, орон нутагт байна. ЛэндМН нь гар утсанд суурилан үйлчилгээ үзүүлж, зөвхөн Улаанбаатар хотод 1 салбартайгаар үйл ажиллагаа явуулдаг билээ.
- ✓ Нийт гаргасан зээл, түүний үнийн дүн: 2.6 сая ширхэг зээл, 560 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Энэ нь дунджаар 7-8 мянган зээл өдөрт гарж байгаа гэсэн үг юм. Энэ нь технологийн шийдлээр хэрэгжиж байгаа гэдгээрээ онцлогтой. Энэ том үйл ажиллагааг 70-80 ажилтантай шийдвэрлэж байна. Хэрэв уламжлалт байдлаар явсан бол 400-500 ажилтан байх шаардлагатай юм. Иймд маш бага хүчээр, технологийн шийдэл дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулж байгаа нь давуу тал болдог бөгөөд цаашид ч үүнийгээ улам төгөлдөржүүлж ажиллах болно.

- ✓ Нийт актив: 77 тэрбум төгрөг боллоо.
- ✓ Орлого: 20 тэрбум төгрөг.
- ✓ Ашиг: 5.5 тэрбум төгрөг. Орлого болон ашгийн хувьд Компанийн түүхэнд байгаагүй өндөр өсөлт үзүүлсэн жил болсон байна.
- ✓ Нийт өөрийн хөрөнгө: 24.2 тэрбум төгрөгт мөн хүрсэн амжилттайгаар энэ оноо үдсэн байна.

ЭХ ҮҮСВЭР:

Манай үйл ажиллагааны үндсэн түүхий эд нь эх үүсвэр байдаг.

- ✓ Эх үүсвэр: 39.2 тэрбум төгрөгийг 2022 онд татан төвлөрүүлсэн байгаа. ХБҮЦ дээр 4.85 тэрбум төгрөг, Бонд дээр 3.1 тэрбум төгрөг, бусдыг нь Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн дагуу хаалттай хүрээнд, итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн байна.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ:

Ковидоос шалтгаалж зах зээлийн нөхцөл байдал амаргүй байсан цаг үед эргэн төлөлтийг уян хатан болгон ажилласны үр дүнд чанаргүй зээлийн хувийг 9%-аас 4%-д буулгаад байна. Салбарын дундаж бол 7-8%-тай байдагтай харьцуулахад манай хувьд 2 дахин бага үзүүлэлтийг гаргаж ажилласан байна.

Та бүхэнд 2022 оны голлох тоон үзүүлэлтийг танилцуулж, тайлбарлалаа. Одоо 2022 оны онцлох үйл явдлын талаар бидний бэлтгэсэн видеотой танилцацгаая.

(2022 оны онцлох үйл явдлын талаар видео үзүүлэв)

Одоо бүгдээрээ аудитлагдсан тайлантай танилцацгаая.

АУДИТЛАГДСАН ТАЙЛАН:

2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайланд хөндлөнгийн хараа бус аудит “Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК аудит хийж ажиллаж, энэхүү тайлан нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу тайлагнагдсан байна гэж хараат бус аудитор дүгнэсэн байна. Та бүхэн дэлгэрэнгүй тайлантай www.lend.mn гэсэн хуудсаар шууд ороод танилцах, мөн өнөөдрийн хурал дээр хараат бус аудитын тайлангийн талаар асуулт асуух боломжтой.

Энэ тайлан дээр харагдаж байгаачлан орлого 20 тэрбум төгрөг, эздийн өмч 77 тэрбум төгрөг, ашиг 5.5 тэрбум төгрөг байна. Та бүхэнд баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулсан “ЛЭНДМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяртаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №2 Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх Төлөөлөн**

удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлын тухай хэлэлцэнэ. Та бүхнийхээ өмнө Хурлын дарга О.Болдбаатар захирлыг урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №2: КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭХ

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

ТУЗ-ийн зүгээс 2022 оны Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “хангалттай” гэж дүгнэснийг та бүхэн дэлгэцээс харж байна. ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 06-ны өдрийн тогтоолоор аудитлагдсан тайланг хүлээн зөвшөөрсөн байгаа.

Компанийн аудитаар “Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК ажилласан. Та бүхний мэдэж байгаагчлан 2018 оноос “Эрнст энд Янг Монголиа” ХХК буюу дэлхийн топ-4 аудитын нэг хараат бус аудитаар ажилласан байсан.

Энэхүү компани маань Аудитын тухай хуулийн дагуу 5 жил ажиллаад завсарлах учиртай байдаг тул энэ жилийн хувьд аудитаа сольсон. Гэхдээ “Эрнст энд Янг Монголиа” ХХК нь мөн олон улсын хэмжээнд давхар ажиллуулж, тайлан нь гарсныг Компанийн вэб хуудсанд байршуулсан байгаа. Тэгэхээр энэ жилийн хувьд ЛэндМН маань 2 аудитын компанитай зэрэг ажиллаад явж байна.

Иймд өнөөдрийн ХЭЭХ-аар ТУЗ-өөс ЛэндМН ББСБ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталж өгөхийг Та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулсан ТУЗ-ийн дарга О.Болдбаатартаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №3 Компанийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг** танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн таныг урья.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ 3: КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн:

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

Компанийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой төвшинд удирдах, стратегийн зорилтдоо хүрэхэд нь ТУЗ нь ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад

компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

2022 оны 3 дугаар сард ХЭЭХ-аар томилогдсон ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ТУЗ хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Компанийн ТУЗ нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит хуралдаж 24 тогтоол, 5 удаа ээлжит бусаар хуралдан 9 тогтоол, нийт 33 тогтоол гаргажээ. Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ нь улиралд доод тал нь 1 удаа хуралдах ёстой байдаг. ТУЗ-ийн гишүүд маань ирцийн хувьд дунджаар 88.8%-тай, биечлэн оролцохгүй тохиолдолд цахим хэлбэрээр оролцож, заавал саналаа өгч ажилласан. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болно.

Та бүхэн энэ слайдаас ямар чиглэлийн тогтоол, шийдвэр гаргасан бэ гэдэг статистик харж байна. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд тайлант жилийн хугацаанд эх үүсвэр, технологийн шинэчлэх шаардлагатай байсан тул Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, LendMN 2.0 программ хангамжид шаардлагатай нэмэлт функцуудыг үнэ төлбөргүй авч ашиглах зорилгын хүрээнд нийт 4 сонирхлын зөрчилтэй хэлцэлд Компанийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд маш нарийн шаардлагаар, судалж шийдвэр гаргадаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг танилцуулъя.

ТУЗ эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг бүхий 1/ Эрсдэлийн удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороодтой ажиллаж байна. Хороодын хурал маань ерөнхий хурлын өмнө заавал хуралддаг ба ерөнхий хурлаар юу хэлэлцэх вэ гэдэгтэй маш нарийн судалж, шийддэг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:

Аудитын хороог би өөрөө ахалж ажилладаг. Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон Компанийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, Компанийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

Гол нь дотоод аудитортой маш нягт ажиллах байдаг бөгөөд дотоод аудитор нь хороонд шууд мэдээлэл өгч ажилладаг юм. Ингэснээр сайн засаглал бий болох үндэс суурь нь бүрэлддэг гэж ойлгож болно.

Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо:

ЗНДЦУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 3 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэн Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх тухай шийдвэрлэж, мөн Компанийн мөрдөж буй ажлын үр дүнтэй холбоотой урамшууллын системийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захирлын томилгоо, гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

Эрсдэлийн удирдлагын хороо:

ЭУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүр эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг.

Туршлагын мэдээлэл:

Манай нийт 9 гишүүний 5 нь ЛэндМН анх хувьцаат компани болох үеэс эхлээд ажилласан туршлагатай гишүүд байна. 4 гишүүн нь өнгөрсөн жил сонгогдоод эхний жилдээ ажиллаж байна. ТУЗ-ийг ийнхүү шинэчлэх нь шинэ санаа, шинэ арга барил, шинэ санаачлага гаргах эерэг талтай байдаг.

Төсвийн мэдээлэл:

2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн 2022 оны цалингийн хэмжээ, зарцуулах төсвийг баталсан бөгөөд уг батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж нэмэлт урамшуулал, шагнал, нөхөн олговор олгоогүй болно. Нийт 9 гишүүн, нэмээд нарийн бичиг гээд 10 хүн цалин авч ажилладаг. Төсвийн гүйцэтгэл нь энд харагдаж байгаачлан 100%-ийн гүйцэтгэлтэй байгаа юм.

Та бүхэнд баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн танд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №4 Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулна уу** хэмээн ТУЗ-ийн дарга, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатарыг урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ 4: КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ УЛИРУУЛАН СОНГОХ ЭСЭХ;

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

Өмнөх хурлаар сонгогдсон ТУЗ-ийн үйл ажиллагаатай та бүхэн танилцлаа. Өнгөрсөн онд нийт 9 гишүүний 1 хараат бус, 3 ердийн гишүүн нь шинэ гишүүд байсан байна. ТУЗ-ийн даргын зүгээс манай ТУЗ маш сайн ажиллаж, Компанийн гүйцэтгэх удирдлагад чиглэлийг цаг тухай бүр өгч ажилласан гэж дүгнэж байгаа.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн маань банк, санхүүгийн салбар, бизнесийн салбар, аудитын салбар зэрэг чиглэлээр мэргэшсэн хүмүүс байна. Иймээс Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3

дугаар хэсгийн дагуу 2022 онд ажилласан 9 гишүүнээ улираан сонгох саналыг та бүхэнд танилцуулж байна.

Улираан сонгогдохоор нэр дэвшиж буй 9 гишүүний танилцуулгыг видео хэлбэрээр хүлээн авч үзнэ үү.

Баярлалаа.

(Улираан сонгогдохоор нэр дэвшиж буй 9 гишүүний танилцуулга видео үзүүлэв)

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчийн танилцуулгатай танилцлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №5 Компанийн ТУЗ-ийн 2022 оны төсвийн саналыг** танилцуулна уу хэмээн “ЛЭНДМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр таныг индэрт урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ 5: ТУЗ-ИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

Компанийн ТУЗ-ийн 2023 оны төсвийн саналыг танилцуулж байна. ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй, нэмээд нарийн бичгийн дарга гээд 10 орон тоотой ажиллаж байна. ТУЗ-ийн дарга, хороодын дарга, 5 гишүүн гэсэн шатлалтай цалин авахаар байгаа. Сардаа 1-1.5 сая төгрөгийн цалинтай, 10 сая төгрөг хурал зохион байгуулах болон бусад зардалд зарцуулагдахаар төсөвлөгдсөн байна. Нийт төсөв маань 153 сая төгрөг байгаа. Энэ төсөв нь 2020 оноос огт өөрчлөгдөөгүй байгаа гэдгийг цохон тэмдэглэж байна.

Иймд хувьцаа эзэмшигч Та бүхнийг ТУЗ-ийн 2023 оны төсвийг батлах санал хураалтад саналаа өгөхийг хүсэж байна.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн ТУЗ-ийн 2023 оны төсвийн саналыг танилцуулсан “ЛЭНДМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяртаа баярлалаа.

Үргэлжлүүлэн **Хэлэлцэх асуудал №6 Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг** танилцуулна уу хэмээн хүсье.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ 6: КОМПАНИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

Өнөөдрийн хурлын хамгийн сүүлийн хэлэлцэх асуудал руу орцгооё. Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдөр Монгол Улсын бүх ББСБ-уудын “Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх” тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

тухай 669 тоот тогтоол гаргасан байна. Уг тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрмийн 4.2.9 дүгээр заалтад уг үйл ажиллагааг эрхэлнэ хэмээн заасан байгаа заалтыг хасаж шаардлагатай байна.

Уг заалтыг хассанаар “ЛэндМН ББСБ” ХК-ийн үйл ажиллагаанд аливаа сөрөг нөлөө учрахгүй. Компани нь энэ чиглэлээр огт үйл ажиллагаа явуулдаггүй болно.

Та бүхэнд баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариултын** хэсэг эхэлж байна. Та бүхэн гараа өргөөд чөлөөтэй асуулт асууж, хариултаа авах боломжтой. Мөн санал хураалтын цахим системээр ирүүлсэн асуултуудыг асуух болно.

Та бүхэн өнөөдрийн хуралд оролцож байгаа албан тушаалтнуудаа хүссэн асуултаа, чөлөөтэй асуух боломжтой. Зааланд манай зохион байгуулагчид микрофон оруулаад өгөөрэй.

АСУУЛТ/ХАРИУЛТЫН ХЭСЭГ:

Асуулт 1: Ногдол ашигаа яаж авах вэ, хэзээ авах вэ?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: ЛэндМН компани маань жил бүр ногдол ашиг олгон ажилладаг. Энэ удаад бид 5.5 тэрбум цэвэр ашигтай 23% буюу 1.3 тэрбум төгрөгийг нэгж хувьцаанд 1.75 төгрөгөөр тооцож олгохоор шийдвэрлэсэн. Бүртгэлийн өдөр 2023 оны 03 сарын 24-ний өдөр байгаа, тэгэхээр та 2023 оны 03 сарын 24-ний өдрөөс өмнө хувьцаа эзэмшиж байсан бол ногдол ашиг авах эрхтэй болно. 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ЛэндМН нь "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК руу ногдол ашгийг шилжүүлнэ. Ингээд 2-оос 3 өдрийн дотор та бүхний нэр дээрх дансанд шууд шилжиж орно.

Асуулт 2: 2023 онд бонд гаргах уу?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: 2023 онд бид зээлийн багцыг 100 тэрбумаас давуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тэгэхээр бид үндсэн үйл ажиллагааны түүхий эд болох эх үүсвэрийг гаргахын тулд нээлттэй болон хаалттай хэлбэрээр бонд гаргана, мөн оны эцсээр бид дахин ХБҮЦ гаргана гэж зорьж байна.

Асуулт 3: 2022 онд ЛэндМН-ийн үйл ажиллагаа тэлсэн явдалд хувьцаа эзэмшигчийн зүгээс баяртай байна. Миний хувьд анх IPO хийсэн цагаас хувьцаа эзэмшиж байна. Энэ цагаас хойш хамгийн өндөр өсөлттэй жил болсон гэж бодож байна. Асуултын хувьд 2023 оны санхүүгийн болон бизнесийн өсөлттэй холбоотой ямар зүйл байгаа вэ? Шинэ бүтээгдэхүүн гарах уу? Мөн хувьцааны ханш бол IPO хийсэн цагаас хойш хангалтгүй байгаад байдаг. Энэ чиглэлээр ажиллах уу? Итгэлцлийн чиглэлээр ямар төлөвлөгөө байгаа талаараа бас танилцуулна уу?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: 2023 онд бид 2022 оныхоо өсөлтийн хурдыг хадгалахыг зорьж байна. Энэ дээр бол манай бизнес хөгжлийн газрын захирал Баасандорж өнөөдөр та бүхэнд дүн тоолж байх хооронд танилцуулахаар байгаа юм. 2023 оноо том зургаар харахад зах зээл дээр урьд өмнө нь гарч байгаагүй, нэлээн уян хатан нөхцөлтэй шинэ бүтээгдэхүүн гаргахаар бэлтгэж ажил дуусаад, одоо нэвтрүүлэх ажил дээрээ төвлөрөөд явж байна. Энэ бүтээгдэхүүн маань эргээд зээлийн багцад том тэлэлтийг авчрах болно гэж харж байна. Цэвэр ашгаа ч мөн өсгөх тал дээр өдөр бүр хичээж ажиллаж байна.

Хувьцааны ханшийн хувьд өнгөрсөн 7 хоногийн байдлаар 30-33 төгрөг дээр хэлбэлзсэн байгаа. Та бүхний харснаар 2022 онд үйл ажиллагаа тэлсэн, орлого түүхэн дээд хэмжээндээ мөн хүрсэн, ашиг мөн тийм хэмжээтэй байна. Бид үүсгэн байгуулагдсан цагаас хойш жил бүр ашигтай ажиллаж, жил бүр ногдол ашиг 1-1.75 төгрөгийг тараасаар байгаа. Энэ нь хувьцааны ханштай харьцуулбал 5-6% гэсэн үзүүлэлт юм.

Хэдий бизнесийн үйл ажиллагаа тэлээд ашигтай байгаа ч Монголын хөрөнгийн зах зээл дээр олон бүтээгдэхүүн, банкууд, бусад компаниуд гарч ирснээр сонголт олон болсон, үүний улмаас эрэлт, нийлүүлэлтийн харьцаа алдагдаж байнуудаа гэж харж байна. Гэхдээ та хувьцаагаа илүү олон жил хадгалаарай, манай үйл ажиллагаа ганхахгүй, тогтвортой, өсөх учраас ирээдүйдээ манай хувьцаа өснө гэдэгт бил итгэлтэй байгаа юм.

Итгэлцлийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн дагуу манай ЛэндМН эрхлэн явуулдаг. 3 жил үйл ажиллагаа явуулсан бол зөвшөөрөл олгодог тул итгэлцлийн үйл ажиллагаа явуулдаг ББСБ-ууд бол цөөхөн. Аппликейшнаар дамжуулан богино хугацаатай үйлчилгээ авах боломжтой, эсвэл урт хугацаатай буюу 1-2 жилийн хугацаатай, өндөр өгөөжтэй нөхцөл сонирхох бол манай ажилтнууд энд мэдээлэл өгч байгаа тул та очиж асуугаад хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргах боломжтой.

Хариулт, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар: Хувьцааны ханш дээр нэмээд хэлэхэд, бид анх 25 төгрөгөөр хувьцаа гаргаж байхад Компанийн өөрийн хөрөнгө 11 тэрбум төгрөг байсан. Одоогийн байдлаар Компанийн өөрийн хөрөнгө 24 тэрбум төгрөг буюу 2 дахин өссөн байна гэсэн үг. Компанийн цаашдын өсөлтийг харгалзахгүйгээр өөрийн хөрөнгөөс харахад л хувьцааны үнэ 25 төгрөг биш 50 төгрөг дээр явах боломжтойг харуулж байгаа юм. Хувьцааны ханш өөрчлөхөд бол удирдлагуудын зүгээс ямар нэгэн байдлаар нөлөөлөх боломжгүй, харин үйл ажиллагааг хамгийн сайн байлгахад анхаарч ажиллаж байна. Өнөөдрийн ханш бол хөрөнгийн зах зээл дээр оролцож буй оролцогч талуудын оролцооноос тогтож байгаа юм. Тэгэхээр хөрөнгө оруулагчдын итгэл бол зөвхөн манайх гэхгүйгээр нийт хөрөнгийн зах зээлд итгэж буй байдлаас мөн шалтгаалж байнуудаа гэж бид харж байна. Үйл ажиллагаа, өсөлт сайн байхын хирээр энэ нь эргээд хувьцааны ханшдаа нөлөөлөх болов уу. Бид бол манай хувьцаа тэдээс тэд болно гэдэг амлалтыг хэзээ ч өгөх боломжгүй, үйл ажиллагааг найдвартай, тогтвортой байлгахад бүхий л анхаарлаа хандуулах болно.

Асуулт 4: Ерөнхийдөө 2 асуулт байна. Шинэ ерөнхийлөгчтэй болсон гэж байсан, энэ хүн маань цаашид яаж ажиллах вэ? ЛэндМН нийгмийн хариуцлагын хүрээнд цаашдаа юу хийх вэ?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: 2023 оны 1 сараас эхлээд К.Мадоно гээд мэргэжилтэн ерөнхийлөгчөөр ажиллаж эхэлсэн. К.Мадоно ерөнхийлөгчийн танилцуулгыг бид мөн саналын дүн тоолох үеэр та бүхэнд танилцуулна. Ерөнхийдөө дурдахад Зүүн Ази, ялангуяа Тайланд, Филиппин зэрэг улсуудад хэрэглээний зээлийн чиглэлээр 41 жил ажилласан маш өргөн туршлагатай, 2020 оноос хойш АНД Глобал гээд ЛэндМН-ийн эцсийн толгой компанид зөвлөхөөр ажиллаж байгаад энэ оноос ЛэндМН-ийн үйл ажиллагаанд гар бие оролцохоор болсон юм. Бидний зорьж буй зүйл бол Зүүн Азийн улс орнуудаас судлаад шинэлэг бүтээгдэхүүнийг энэ зах зээлд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үр ашигт байдлыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах юм. Энэ хүний туршлагатай уяад 1-2 жилийн дотор бүх үйл ажиллагаагаа шинэчилнэ гэж харж байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд ногоон зээлийн бүтээгдэхүүн гаргах гээд багаа томилсон, судалгаа хийгдэж дуусаад одоо хөгжүүлэлтэд ороход бэлэн болсон байгаа. Та бүхэнд санал тооллогын үеэр танилцуулах болно.

Хариулт, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар: Мөн нэмээд хэлэхэд К.Мадонотой ТУЗ-ийн хурал дээр танилцсан, түүний үүрэг бол илүү гүйцэтгэх захиралд зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллах, туршлагаа хуваалцахад байгаа. Компанийн засаглалын хувьд хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирал гэсэн бүтэц хэвээрээ, засаглалд ямар нэгэн шууд оролцоогүй хүн юм. Компанид олон улсаас эх үүсвэр, бонд, хөрөнгө оруулалт татахад зориулан, олон улсын жишгээр ерөнхийлөгч гэсэн статус үүсгээд явсан юм.

Асуулт 5: Автомашины зээлд шинэ машин нэмэгдэж байгаа юу?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: ЛэндМН нь 2021 оноос автомашины зээлийг зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна. Байгал орчинд ээлтэй гэдэг утгаараа зөвхөн эко автомашины зээлийг зах зээлд гаргаж байгаа юм. Цаашдаа бол нэр төрлийг нэмэгдүүлэх тал дээр судалж байна. Тухай үедээ та бүхэнд мэдээлээд явна.

Хариулт, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар: Машины зээлийн хувьд нэр төрөл нь одоо зах зээлд зарагддаг 70-80 хувийн машины төрлүүд байгаа юм. Бид зөвхөн тэнд төвлөрч байна. Шинээр гарч буй машин, Lexus, Land 300 гэдэг ч юм уу зээл гаргахад их хэмжээний эх үүсвэр шаардагдахаар байгаа юм. Та бүхний мэдэж байгаачлан эх үүсвэр гэдэг бол бидэнд амин чухал тул түүгээр хязгаарлагддаг, нөгөө талаас нь бид хүртээмжтэй байдлыг анхаарч ажилладаг.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Заалны асуулт одоогоор байхгүй тул санал хураалтын системээр ирүүлсэн асуултуудыг асууя. Дундуур нь заалнаас асуух боломжтой тул та бүхэн гараа өргөөд асуугаарай.

Асуулт 6: Итгэлцлийн үйлчилгээгээ хүүхдэд зориулсан хуримтлалын хэлбэрээр сайжруулж өгөх боломжтой юу?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Бүрэн боломжтой. Бид аппликейшн дээрээ итгэлцлийн үйлчилгээнд зориулан сайжруулалт хийхээр ажиллаж байна. Мөн та хүүхдийнхээ нэр дээр гэрээ байгуулаад хамтран ажиллах бүрэн боломжтой.

Хариулт, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар: Итгэлцлийн үйлчилгээ нь банкны хадгаламжтай төстэй үйлчилгээ байгаа юм. Гэхдээ бид ББСБ учраас олон нийтэд зарлаж болдоггүй. Тэгэхээр та биечлэн гүйцэтгэх захиралтай уулзаж, нөхцөлөө харилцан тохироод эх үүсвэрээ байршуулах боломжтой.

Асуулт 7: Орон нутагт нээх үү?

Хариулт, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар: Орон нутагт салбар нээнэ гэсэн төлөвлөгөө одоогоор байхгүй. Өнөөдрийн байдлаар орон нутагт салбар нээгээчээ гэдэг хүсэлт бол хэрэглэгчдээс ирж байгаагүй. Цахимаар ашигладаг учраас заавал биечлэн ирээд байх шаардлагагүй, үйлчилгээтэй холбоотой зүйлээ утасдаад асуух боломжтой, зээлийн гэрээ байгуулах бол хамгийн ойрхон нотариат дээрээ очоод байгуулах боломжтой.

Хөдөө орон нутагт зээл олголт хэвийн гарч байгаа.

Асуулт 8: Хүүхдэдээ батлан даалт гаргаад танай үйлчилгээг хэрэглүүлэх боломжтой юу?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Яг энэ төрлийн бүтээгдэхүүн байж болох эсэх дээр бид яг одоо ажиллаж байгаа юм. Өсвөр насны хүүхэд маань санхүүгийн үйлчилгээг өөрөө авах, бие даан хэрэглэх боломж олгох нь санхүүгийн боловсролыг нь дээшлүүлэхэд үр нөлөөтэй гэж бид дүгнэж байна. Судалгаа явагдаж байгаа тул тодорхой хугацааны дараа зэх зээлд гарах боломж бүрдэх байх.

Асуулт 9: Зээлийн хүүгээ яагаад нэмээд байгаа вэ? Шимтгэлээ бууруулах уу? Цаашид яах вэ?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Сүүлийн хэдэн жилийн турш зах зээлийн нөхцөл байдал нэлээн хүнд, ам.долларын ханш 2,500-3,500 төгрөг болсон. Үүнтэй уялдаад Монголбанк бодлогын хүүгээ удаа дараа нэмж, 6 хувиас 13 хувь болгож өсгөсөн байдаг. Энэ бүрд ЛэндМН-ийн хувьд эх үүсвэрийн зардал өсдөг буюу нөлөөлөлд өртдөг юм. Бид хүү өсгөхгүй байх тал дээр ажилласан боловч ямар ч араггүй болсны улмаас үйл ажиллагааны ашигт байдлыг харгалзаж үзээд нэг удаа хүүгээ өсгөхөөс өөр сонголтгүй болсон. Шимтгэлийн хувьд цаанаа зээл олгоход гарч буй зардалтай шууд хамааралтай байдаг. Банкны гүйлгээ, технологийн зардал, мессежний төлбөр зэрэг зээл олгох, төлөхтэй холбоотой гуравдагч этгээдүүдэд төлдөг төлбөрт явдаг юм. Би дөнгөж сая шимтгэлээ тогтмол болгож бууруулсан.

Цаашдаа эдийн засгийн нөхцөл байдалтай холбогдуулан хүүгээ бууруулах боломж байхыг үгүйсгэхгүй юм.

Асуулт 10: Автомашин борлуулдаг ченжүүдтэй тулж ажилламаар байна. 22-н товчоон дээр ямар ББСБ-аар машин авахыг ченжүүд л шийдэж байна. Тэгэхээр олгосон зээлээс урамшуулал өгөх ёстой юм шиг. Энэ тал дээр ямар бодлого барьж байна вэ?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Автомашины зээлийн хувьд зээлийн эрхийг нь хиймэл оюун ухаанаар автоматаар тодорхойлж байна. Тэгэхээр уламжлалт зээлийн үйлчилгээ шиг автомашин борлуулдаг хүмүүстэй ажиллах, зээл өгөх шаардлага үүсэхгүй. Бид энэ үйлчилгээгээ сайжруулах тал дээр ажиллаж байгаа, Японы компанитай хамтрахаар ярилцаж байна.

Хариулт, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар: Хүмүүс эхлээд машинаа олоод зээлээ яах эсэхээ шийддэг бол манай автомашины зээлийн гол онцлог нь эхлээд гар утсаараа дамжуулаад зээлийн эрхээ тооцоолуулчихаад машинаа шийддэгт байгаа юм. Жишээлбэл, би 20-25 сая төгрөгт машин авах боломжтой юм байна гэдгээ мэдчихээд, түүний дараа зээлдээ тохируулаад машинаа хайж олоод авдаг. Үүгээрээ уламжлалт зээлийн үйлчилгээнээс ялгардаг.

Асуулт 12: Томоохон дэлгүүр, шопуудад төлбөр төлөхөд ЛэндМН гэсэн сонголт бий болох уу?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Өнгөрсөн жил бид LendPAY гээд худалдан авалтаа шимтгэл, хүүгүйгээр хувааж авдаг зээлийн үйлчилгээ нэвтрүүлсэн байдаг. Манай 196 мянган харилцагч энэ үйлчилгээг авах боломжтой. Одоогийн байдлаар 400 мерчант байгаа. Энд асуусан үйл ажиллагаа бол мөн явагдаж байгаа. Тун удахгүй томоохон дэлгүүр, худалдааны төвүүдэд LendPAY үйлчилгээг ашиглах боломж нээгдэх болно. Одоо ашиглах боломжтой мэдээлэл нь аппликейшн дээр нээлттэй байгаа.

Асуулт 13: Эхний улирлын санхүүгийн тайлан гарсан байгаа юу?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Бид хувьцаат компани гэдэг утгаараа улирал бүрийн тайлангаа дараа сарын 15-ны өдрийн дотор гаргаж ажилладаг. Эхний улирлын тайлан өнгөрсөн сард гарсан байгаа. Тодруулаад хэлэхэд, зээлийн багц маань 78 тэрбум төгрөг, орлого 9 тэрбум төгрөг, цэвэр ашиг 3.7 тэрбум төгрөгт дөхсөн үзүүлэлттэй байгаа. Цэвэр ашгийн хувьд өнгөрсөн жил 5.5 тэрбум төгрөг байсантай харьцуулбал цэвэр ашиг энэ жилийн нэгдүгээр улиралд хэдийнээ 70-80 хувьд нь хүрчихсэн явж байна.

Улирлын тайлангаас та бүхэн маань эдгээр мэдээллээс гадна Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага гээд бусад мэдээллийг авах боломжтой.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

ХУРЛЫН ДЭГИЙН ДАГУУ ХЭЛЭЛЦЭЖ БАЙГАА АСУУДЛУУДАЙ ХОЛБООТОЙ САНАЛ ХУРААЛТ ЯВАГДЛАА. САНАЛ ХУРААЛТЫН ХУГАЦАА 20 МИНУТ.

ХУРЛЫН ДЭГИЙН ДАГУУ САНАЛ ХУРААЛТЫН ХУГАЦАА ДУУСАЖ, САНАЛ ХУРААЛТ ЭХЭЛЖ БАЙНА.

Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хурааж дууслаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах хэсэг эхэлж байна. Индэрт тооллогын комиссын дарга С.Батбуянг урьж байна.

Тооллогын комиссын дарга С.Батбуян:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэж дууслаа. Тооллогын комиссын бүрэлдэхүүнд миний бие С.Батбуян, гишүүд Ж.Булган, Х.Одончимэг, М.Оюун-Эрдэнэ гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа. Хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулбал:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах санал хураалтын дүн:
 - 1.1. Зөвшөөрсөн 623,384,428 ширхэг хувьцааны санал буюу 100%;
 - 1.2. Татгалзсан 0 ширхэг хувьцааны санал буюу 0%;
 - 1.3. Түдгэлзсэн 0 ширхэг хувьцааны санал буюу 0% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг батлах санал хураалтын дүн:
 - 2.1. Зөвшөөрсөн 623,384,428 ширхэг хувьцааны санал буюу 100 %;
 - 2.2. Татгалзсан 0 ширхэг хувьцааны санал буюу 0%;
 - 2.3. Түдгэлзсэн 0 ширхэг хувьцааны санал буюу 0% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
3. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах санал хураалтын дүн:
 - 3.1. Зөвшөөрсөн 623,384,428 ширхэг хувьцааны санал буюу 100%;
 - 3.2. Татгалзсан 0 ширхэг хувьцааны санал буюу 0%;
 - 3.3. Түдгэлзсэн 0 ширхэг хувьцааны санал буюу 0% байх тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдийг улируулан сонгох асуудлаар нэр дэвшигчдэд өгсөн санал хураалтын дүн:
 - 4.1. О.Болдбаатар 623,977,022 ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын 16.68%;
 - 4.2. В.Баярсайхан 623,726,365 ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын 16.68%;
 - 4.3. С.Энх-Амгалан 623,134,007 ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын 16.66%;

- 4.4. Б.Хос-Эрдэнэ 623,128,173 ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын 16.66%;
- 4.5. Б.Итгэл 622,991,123 ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын 16.66%;
- 4.6. Ц.Ууганбаяр 623,349,878 ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын 16.67% байх тул Компанийн тухай хуулийн 77.4 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д зааснаар шийдвэр хүчинтэй.
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг улируулан сонгох асуудлаар нэр дэвшигчдэд өгсөн санал хураалтын дүн:
- 5.1. С.Боргил 623,542,884 ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн хараат бус гишүүдэд өгсөн нийт саналын 33.34%;
- 5.2. Ж.Жаргалсүрэн 623,231,821 ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн хараат бус гишүүдэд өгсөн нийт саналын 33.33%;
- 5.3. Д.Галхүү 623,378,579 ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн хараат бус гишүүдэд өгсөн нийт саналын 33.33% байх тул Компанийн тухай хуулийн 77.4 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д зааснаар шийдвэр хүчинтэй.

Хоёр. Компанийн тухай хуулийн 72.1 дүгээр зүйлд заасны дагуу Хэлэлцэх асуудалтай холбоотой хүчингүй болсон саналын хуудас 2 (хоёр) болохыг мэдэгдсүгэй. Үүнд:

2.1. Хэлэлцэх асуудал №1: Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах, Хэлэлцэх асуудал №2: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг батлах; Хэлэлцэх асуудал №3: Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлах асуудлаар 3,964 ширхэг хувьцаа эзэмшиж буй 1 хувьцаа эзэмшигч аливаа санал тэмдэглээгүй тул тухайн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

2.2. Хэлэлцэх асуудал №4: Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдийг улируулан сонгох; Хэлэлцэх асуудал №5: Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох асуудлаар 3,964 ширхэг хувьцаа эзэмшиж буй 1 хувьцаа эзэмшигч аливаа санал тэмдэглээгүй тул тухайн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

Өөрөөр хэлбэл, 3,964 ширхэг хувьцаа эзэмшиж буй 1 хувьцаа эзэмшигч саналын хуудсанд аливаа санал тэмдэглээгүй байх тул баталсан саналын хуудасны загвар (5а, 5б)-ын дагуу хүчингүй болсон саналын хуудас 2 (хоёр) гэж тоологдсон болно.

Өмнө танилцуулсан санал хураалтын дүнд хүчингүй болсон саналын тоо байгааг танилцуулсан ба санал хураалтын системд арван мянганы орноор нарийвчилсан учир санал хураалтын дүнгийн нэгтгэл нь арван мянганы орноор нарийвчилсан хувиар гарч байгааг дахин дурдаж байна.

Ийнхүү тооллогын комиссын тогтоолыг гаргаж 2023 оны 04 сарын 15-ны өдрийн “ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын санал хураалтын дүнг баталгаажуулж байна. Та бүхэнд баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг баталлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа Эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах хэсэг эхэлж байна.

Хэлэлцсэн асуудлуудтай холбоотой санал хураалтын дүнд үндэслэн хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг танилцуулна уу хэмээн хурлын дарга О.Болдбаатар таныг индэрт урьж байна.

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

ХЭЭХ-аас гарсан шийдвэрүүдийг уншиж танилцуулав.

(ХЭЭХ-аас гарсан шийдвэрийг хавсаргав)

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хамтран ажилладаг байгууллагууд, бүх харилцагч та бүхэндээ баярлалаа. “ЛэндМН ББСБ” ХК нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нийт 6 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. 2023 онд ЛэндМН-ийн хамт олон бид улам хичээн ажиллах болно.

Бидэнд үргэлж итгэл хүлээлгэж, дэмжин ажилладаг нийт харилцагчид, хамтран ажилладаг аж ахуйн нэгж, албан байгууллагууд болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлье Та бүхний ажилд амжилт хүсье.



ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

О.БОЛДБААТАР

ЛэндМН ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга, ХЭЭХ-ын дарга

М.ТҮВШИНЖАРГАЛ

ЛэндМН ББСБ ХК-ийн Санхүү, үйл ажиллагаа хариуцсан захирал,
ХЭЭХ-ыг зохион байгуулах комиссын дарга

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Б.ОЮУНБОЛД

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга